



## Үндэсний виз мэдүүлэх заавар Германд амьдарч буй эцэг, эх рүүгээ нүүж очих хүүхдүүдийн виз (Kindernachzug)

### Үндсэн заавар

- Төрсний гэрчилгээ, гэрлэлтийн баталгаа болон бусад баримт бичгийн эх хувийг өгнө. Таны визийн мэдүүлгийг шийдвэрлэсний дараа эх хувийг буцаан олгоно.
- Таны визийн мэдүүлгийг шийдвэрлэхийн тулд Герман дахь Гадаадын Харьяат Иргэдийн газраас зөвшөөрөл авдаг. Тус газраас зөвшөөрөл ирсний дараа виз олгох боломжтой.
- Визийн мэдүүлгийг өгөхдөө нислэгийн тийзийн захиалга өгөх шаардлагагүй.
- ЭСЯ-наас нэмэлт бичиг баримт шаардаж болно.
- Бүрэн гүйцэд бус визийн мэдүүлэг өгөх нь шийдвэрлэх хугацааг удаашруулах бөгөөд цаашлаад татгалзах эрсдэлтэй.
- Визийн мэдүүлгийг шийдвэрлэх хугацаа дуусаагүй байхад лавлан асуух шаардлагагүй. Энэ нь визийн хэлтсийн ажлын ачааллыг нэмэгдүүлэх тул хариулах боломжгүй.
- Визийн мэдүүлгийг шийдвэрлэхэд олон хүчин зүйлс, нөхцөл байдлыг харгалзан шалгах учраас зааврын дагуу бичиг баримтаа бүрэн бүрдүүлж өгөх нь виз гарах баталгаа биш.
- Маягтыг визийн хэлтсээс үнэ төлбөргүй авах боломжтой. Виз мэдүүлэхэд үйлчилгээний хураамж төлөх бөгөөд тухайн хураамжийг виз татгалзсан, мэдүүлгээ буцаан авсан аль ч тохиолдолд эргүүлэн олгохгүй.
- Виз мэдүүлэх бичиг баримт бүрдүүлэхдээ ямар нэгэн байгууллага эсвэл гуравдагч этгээдийн тусалцаа, үйлчилгээг ашиглах шаардлагагүй. Өгсөн мэдүүлгийн хариуцлага, үр дагаврыг зөвхөн виз мэдүүлэгч өөрөө хариуцна.

### Ерөнхий мэдээлэл

Асран хамгаалах эрхтэй эцэг, эх хоёул эсвэл аль нэг нь Герман улсад амьдардаг бол насанд хүрээгүй, гэрлээгүй хүүхдүүд нь Германы Оршин суух тухай хуулийн 32-р зүйлд (§32 AuentG) зааснаар эцэг, эх рүүгээ нүүж очих боломжтой.

Виз мэдүүлэгч нь ЭСЯ-ны Консулын хэлтэст биечлэн ирж бичиг баримтаа өгнө. 18 нас хүрээгүй виз мэдүүлэгч асран хамгаалах эрх бүхий хүмүүсийн хамт ирнэ. Эцэг эхийн аль нэг нь Германд амьдардаг бол нотариатаар баталгаажуулсан зөвшөөрлийг хавсаргана.

Герман дахь Гадаадын харьяат иргэдийн газар зөвшөөрлөө өгөх ёстой учраас бүрэн гүйцэд визийн мэдүүлгийг эцэслэн шийдвэрлэхэд багадаа 2 сарын хугацаа шаардлагатай. Ийм төрлийн визийн мэдүүлгийг шийдвэрлэх явцад Монгол Улсын Иргэний бүртгэл мэдээлэл, бусад холбогдох байгууллагаас олгосон гэрчилгээ, лавлагаа, шүүхийн шийдвэр, тодорхойлолт гэх мэтийн бичиг баримтын үнэн зөвийг шалгах шаардлага (Urkundenüberprüfung) олонтаа тохиолддог. Энэ нь визийн мэдүүлгийг шийдвэрлэх хугацааг уртасгаж болох бөгөөд нэмэлт төлбөртэй байна. Бичиг баримт хянан шалгах тухай мэдээллийг доорх холбоосоос авна уу: <https://ulan-bator.diplo.de/mn-de/service/-/2180306>.



<b>Визийн мэдүүлэгт өгөх бичиг баримтын жагсаалт</b>		
<p>Визийн мэдүүлэгт өгөх бичиг баримтуудыг эх хувиас гадна 2 хувь хуулбарын хамт өгнө. Визийн мэдүүлгийг шийдвэрлэсний дараа бичиг баримтын эх хувийг буцаан олгоно. Англиас бусад хэл дээрх бичиг баримтыг герман орчуулгын хамт өгнө. Бичиг баримтаа доорх дарааллаар эрэмбэлнэ үү.</p>		
1	Бүрэн гүйцэд бөглөсөн, виз мэдүүлэгч гарын үсгээ зурсан үндэсний визийн маягт 2 хувь ("VIDEX" маягт)	<input type="checkbox"/>
2	Биометрийн шаардлага хангасан 35*45 мм хэмжээтэй 2 хувь цээж зурагны нэгийг үндэсний визийн маягтын цээж зураг байрлах хэсэгт нааж хоёр дахь зургийг нь наалгүй авч ирнэ.	
3	Хүчинтэй гадаад паспорт	
4	Гадаад паспорт эзэмшигчийн хувийн мэдээлэл бүхий нүүрний хуулбар	
5	Төрсний гэрчилгээ	
6	Байгаа бол: Асран хамгаалагчийг тогтоосон шүүхийн шийдвэр Байгаа бол: Үрчлүүлсэн тухай шийдвэр болон үрчлүүлсэний гэрчилгээ	
7	Германд амьдарч байгаа эцэг, эхийн оршин суугаа хаягийн бүртгэл. Жишээ нь сүүлийн 6 сар дотор олгосон бүртгэлийн лавлагаа (Meldebescheinigung)	
8	Германд амьдарч буй эцэг, эхийн паспорт эсвэл иргэний үнэмлэхний хуулбар.	
9	Германы болон Европын Холбооны бус иргэдийн хувьд оршин суух зөвшөөрлийн хуулбар.	
10	Визийн хугацааг хамрах эрүүл мэндийн даатгал. Виз олгох боломжтой болсны дараа өгөх ба энэ талаар Элчин сайдын яамнаас утсаар мэдэгдэх болно.	
<b>Монголоос өөр орны иргэншилтэй виз мэдүүлэгч</b>		
11	Монгол Улсад удаан хугацаагаар оршин суух зөвшөөрөл	
<b>Хураамж</b>		
12	Визийн хураамж 75 еврог монгол төгрөгөөр	
<b>Визийн мэдүүлгийн бүрэн гүйцэд байдал</b>		
	<p>Визийн мэдүүлэгт шаардлагатай бичиг баримт бүрэн гүйцэд байгаа эсэх:</p> <p><input type="checkbox"/> Гийм</p> <p><input type="checkbox"/> Гүгүй, чагтлаагүй үлдсэн бичиг баримт/мэдээлэл дутуу</p>	
<b>Бүрэн гүйцэд бус визийн мэдүүлэг өгөх тухай мэдэгдэл</b>		
<p>Миний визийн мэдүүлэг бүрэн гүйцэд бус байгаа талаар надад мэдээлсэн. Бичиг баримт дутуу мэдүүлэг өгөх нь визийг татгалзах шалтгаан гэдгийг миний бие ойлгож байгаа бөгөөд визийн мэдүүлгээ өгөх хэвээр байгаа гэдгийг мэдэгдэж гарын үсгээ зурсан болно.</p> <p>_____ газар, огноо, гарын үсэг</p>		